



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А1223

Булган

Г Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Соёл, амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу шат дараатайгаар хийх ажлын зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2018 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Эчо дизайн” ХХК-тай 32 800 000 /гучин хоёр сая найман зуун мянга/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг олгосугай.

2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, журмын дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /У.Бямбасүрэн/-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Эчо дизайн” ХХК-ийн захирал /А.Одонтунгалаг/-д даалгасугай.

4. Энэхүү ажлын санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу 2018 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

З.БАТЗОРИГ